



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 198

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, 63 дугаар зүйлийн 63.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Силвер лайт секюритиз” ХХК-д үнэт цаасны брокерын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.

2. Үнэт цаасны брокерын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Силвер лайт секюритиз” ХХК /Ц.Цэлмүүн/-д үүрэг болгосугай.

1/ Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, харилцагч, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн ажиллах;

2/ Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдуулан зохих өөрчлөлтийг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх;

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН